

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/17/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № ЧБА-2022/17/НА-СТР-ТШЗ
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ



0200200378

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,334,672.00</u>	<u>5,576,459.00</u>
33	АВЛАГА	2,329,352.00	00.00
335	Бусад авлага	2,329,352.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,329,352.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	118,400.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	118,400.00	00.00
34714	Томилолтын урьдчилгаа	118,400.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,886,920.00	5,576,459.00
354	Хангамжийн материал	8,886,920.00	5,576,459.00
35410	Бичиг хэргийн материал	370,500.00	273,000.00
35420	Аж ахуйн материал	3,369,700.00	3,861,759.00
35470	Бусад хангамжийн материал	5,146,720.00	1,441,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>39,261,310.44</u>	<u>27,869,597.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,261,310.44	27,869,597.29
392	Биет хөрөнгө	39,001,310.44	27,669,597.29
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,800,000.00	9,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,913,888.51	-7,213,888.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,836,900.00	29,216,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,794,194.96	-7,039,916.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,434,576.00	10,314,576.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,462,082.09	-7,407,873.21
39217	Ном	100,000.00	00.00
393	Биет бус хөрөнгө	260,000.00	200,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-40,000.00	-100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>50,595,982.44</u>	<u>33,446,056.29</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>50,595,982.44</u>	<u>33,446,056.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	50,595,982.44	33,446,056.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,434,260.00	9,434,260.00
51101	Өмч: - төрийн	9,434,260.00	9,434,260.00
512	Хуримтлагдсан үр дүн	40,943,542.44	23,793,616.29
51210	Өмнөх үеийн үр дүн	40,943,542.44	27,533,542.42
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-3,739,926.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	218,180.00	218,180.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>50,595,982.44</u>	<u>33,446,056.29</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	168,682,400.00	184,596,948.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	2,678,748.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,678,748.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,678,748.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,520,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	158,748.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,682,400.00	181,918,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	168,682,400.00	181,418,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	168,682,400.00	181,418,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	153,720,181.09	186,074,107.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	153,720,181.09	186,074,107.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,095,185.09	166,528,574.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,073,329.00	88,807,219.00
210101	Үндсэн цалин	63,402,833.00	60,355,531.00
210104	Урамшуулал	26,670,496.00	28,451,688.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,476,376.00	10,989,720.14
210201	Тэтгэврийн даатгал	10,476,376.00	10,989,720.14
2104	Хангамж, бараа материалын зардал	17,068,042.00	27,590,819.00
210401	Бичиг хэрэг	3,400,750.00	5,446,185.00
210402	Тээвэр, шатахуун	8,383,980.00	15,286,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	783,632.00	629,459.00
210404	Ном, хэвлэл	3,212,480.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	961,700.00	5,273,575.00
210408	Бараа материал акталсны зардал	325,500.00	955,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,620,000.00	6,116,419.00
210604	Урсгал засвар	3,620,000.00	6,116,419.00
2107	Томилолт, зочны зардал	2,829,400.00	653,000.00
210702	Дотоод албан томилолт	2,829,400.00	653,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	417,636.00	1,055,374.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	182,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,536.00	137,124.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	70,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,610,402.09	31,316,023.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,455,500.00	6,928,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,535,600.00	9,289,357.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,619,302.09	15,098,646.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,624,996.00	19,545,532.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,918,000.00	7,891,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,918,000.00	7,891,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,706,996.00	11,654,532.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,706,996.00	11,654,532.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	14,962,218.91	-1,477,159.45
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	374432.70	2262766.68
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	374,432.70	2,262,766.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-374,432.70	-2,262,766.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	14,587,786.21	-3,739,926.13

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	168,682,400.00	184,438,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	2,520,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,520,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,520,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,520,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,682,400.00	181,918,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	168,682,400.00	181,418,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	168,682,400.00	181,418,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	168,682,400.00	184,438,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,682,400.00	184,438,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,629,404.00	166,699,667.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,434,086.00	88,807,214.00
210101	Үндсэн цалин	60,690,909.00	60,404,049.00
210104	Урамшуулал	29,743,177.00	28,403,165.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,462,999.00	10,985,373.14
210201	Тэтгэврийн даатгал	8,281,599.00	8,159,239.69
210202	Тэтгэмжийн даатгал	713,500.00	874,074.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	376,300.00	699,256.60
210204	Ажилгүйдлийн даатгал	248,100.00	141,826.98

210205	Эрүүл мэндийн даатгал	843,500.00	1,110,975.66
2104	Хангамж, бараа материалын зардал	20,266,583.00	17,152,648.00
210401	Бичиг хэрэг	2,957,250.00	2,593,750.00
210402	Тээвэр, шатахуун	10,464,001.00	11,193,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	783,632.00	629,459.00
210404	Ном, хэвлэл	5,000,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,061,700.00	2,376,289.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,121,800.00	24,675,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,310,000.00	17,989,600.00
210602	Тавилга	339,900.00	00.00
210604	Урсгал засвар	3,471,900.00	6,685,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,733,500.00	534,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	417,636.00	1,055,374.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	170,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,536.00	137,124.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	33,450.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	70,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,192,800.00	23,489,158.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	12,740,351.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,192,800.00	10,748,807.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,052,996.00	17,738,532.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,346,000.00	6,084,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,346,000.00	6,084,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,706,996.00	11,654,532.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,706,996.00	11,654,532.86

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	40,943,542.44	50,595,982.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	40,943,542.44	50,595,982.44
D01	2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	40,943,542.44	50,595,982.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-13,410,000.02	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	27,533,542.42	37,185,982.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,739,926.13	-3,739,926.13
D09	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	23,793,616.29	33,446,056.29

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	181,418,200.00	172,283,667.14	9,134,532.86	94.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	181,418,200.00	172,283,667.14	9,134,532.86	94.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	175,287,300.00	166,199,667.14	9,087,632.86	94.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,808,700.00	88,807,214.00	2,001,486.00	97.80
210101	Үндсэн цалин	60,681,500.00	60,404,049.00	277,451.00	99.54
210104	Урамшуулал	30,127,200.00	28,403,165.00	1,724,035.00	94.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,259,200.00	10,985,373.14	1,273,826.86	89.61
210201	Тэтгэврийн даатгал	8,627,300.00	8,159,239.69	468,060.31	94.57
210202	Тэтгэмжийн даатгал	725,900.00	874,074.21	-148,174.21	120.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	908,600.00	699,256.60	209,343.40	76.96
210204	Ажилгүйдлийн даатгал	181,500.00	141,826.98	39,673.02	78.14
210205	Эрүүл мэндийн даатгал	1,815,900.00	1,110,975.66	704,924.34	61.18

2104	Хангамж, бараа материалын зардал	17,597,100.00	17,152,648.00	444,452.00	97.47
210401	Бичиг хэрэг	3,132,000.00	2,593,750.00	538,250.00	82.81
210402	Тээвэр, шатахуун	10,227,100.00	11,193,150.00	-966,050.00	109.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,356,300.00	629,459.00	726,841.00	46.41
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	360,000.00	640,000.00	36.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,881,700.00	2,376,289.00	-494,589.00	126.28
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,862,400.00	24,675,300.00	187,100.00	99.25
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,174,100.00	17,989,600.00	184,500.00	98.98
210604	Урсгал засвар	6,688,300.00	6,685,700.00	2,600.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	1,397,700.00	534,600.00	863,100.00	38.25
210702	Дотоод албан томилолт	1,397,700.00	534,600.00	863,100.00	38.25
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,689,200.00	1,055,374.00	1,633,826.00	39.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,786,800.00	500,000.00	1,286,800.00	27.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	144,000.00	72,000.00	66.67
210803	Даатгалын үйлчилгээ	170,800.00	170,800.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,100.00	137,124.00	27,976.00	83.06
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	33,450.00	10,550.00	76.02
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	306,500.00	70,000.00	236,500.00	22.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25673000.00	22989158.00	2,683,842.00	89.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,380,900.00	12,240,351.00	2,140,549.00	85.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,292,100.00	10,748,807.00	543,293.00	95.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6130900.00	6084000.00	46,900.00	99.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,130,900.00	6,084,000.00	46,900.00	99.24
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,130,900.00	6,084,000.00	46,900.00	99.24
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	181,418,200.00	172,283,667.14	9,134,532.86	94.96
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	181,418,200.00	169,763,667.14	11,654,532.86	93.58
132001	Орон нутгийн төсвөөс	181,418,200.00	169,763,667.14	11,654,532.86	93.58
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	2,520,000.00	-2,520,000.00	
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,520,000.00	-2,520,000.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	04.00	04.00		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	02.00	02.00		
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00		
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00		

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		500,00.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		500,00.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		500,00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210604	Урсгал засвар		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		500,00.00
210901	үйлчилгээний бусад зардал		
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэхдээ, Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон Аймаг, сумын ИТХ-ын бодлого зорилтыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах чиглэлээр зохих шийдвэрийг гаргаж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1.2 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 186.0 сая төгрөгийн 1 хувь буюу 1.8 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 1.4 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,446.0 мянган төгрөг буюу 33.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	2,329.3	0.0	-2,329.3
Бараа материал	8,886.9	5,576.4	-3,110.5
Үндсэн хөрөнгө	39,261.3	27,869.6	-11,391.7
Нийт хөрөнгө	50,595.9	33,446.0	-17,149.0
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	50,595.9	33,446.0	-17,149.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	50,595.9	33,446.0	-17,149.0

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,576.4 мянган төгрөг болж 3,110.5 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, бусад хангамжийн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,869.6 мянган төгрөг болж 11,391.7 мянган төгрөг болж буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн данснаас хөрөнгө акталж, шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 33,446.0 мянган төгрөг болж 17,149.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 184,596.9 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан санхүүжилт болон үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 186,074.1 мянган төгрөгөөр буюу 21.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан урсгал засвар, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 196,415.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 14,997.3 мянган төгрөгөөр бууруулж 181,418.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 181,418.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 172,283.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 181,418.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 172,283.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 172,283.6 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 500.0 мянган төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 156 мэдээллээс хугацаандаа оруулсан 155, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 24-ний өдөр